



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Г

Г

Хуралд оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Төрийн нарийн бичгийн дарга С.Ламбаа, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Цогтбаатар нарыг Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотод зохион байгуулагдах "Ази Номхон далайн бус нутгийн эмзэг бүлгийн хүн ам, орчны эрүүл мэнд" сэдэвт олон улсын хуралд 2016 оны 03 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцохыг зөвшөөрсүгэй.
2. Хуралд оролцох удирдамжийг хавсралтаар баталж, илтгэх хуудасыг ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Цогтбаатар/-д үүрэг болгосугай.
3. Дээрх хугацаанд захирлын үүрэг гүйцэтгэгчийн албан үүргийг тус хүрээлэнгийн Хоол судлалын төвийн дарга Ж.Батжаргалаар түр орлон гүйцэтгүүлсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР



080219



ХУРАЛД ОРОЛЦОХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Ази, Номхон далайн бүс нутгийн эмзэг бүлгийн хүн ам, орчны эрүүл мэнд олон улсын хуралд илтгэл тавих, хуралдаан даргалах

Хоер. Арга хэмжээ болох газар

БНСУ-ын Сөүл хот

Гурав.Хугацаа

2016 оны 03 дугаар сарын 09-11

Дөрөв.Санхүүжилт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Тав. Үйл ажиллагааны чиглэл

- Орчны эрүүл мэндийн Азийн бүс нутгийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, санал солилцох *
- Ази, Номхон далайн бүс нутгийн эмзэг бүлгийн хүн ам, орчны эрүүл мэнд олон улсын хуралд Монгол улсыг төлөөлж ажиллах
- Хуралдаан даргалах
- Монгол улс дахь орчны эрүүл мэндийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар илтгэл тавих, хэлэлцүүлэх
- БНСУ-ын хүрээлэн буй орчин судлалын үндэсний хүрээлэнтэй холбоо тогтоох

Зургаа. Хүрэх үр дүн

- Бүс нутгийн холбогдох байгууллагуудтай цаашдын хамтын ажиллагаа сайжирна.
- БНСУ-ын хүрээлэн буй орчин судлалын үндэсний хүрээлэнтэй хамтын ажиллагааны хүрээнд санал солилцено.
- Олон улсын хуралд тавьсан илтгэлд бусад орнуудын төлөөлөгчидтэй санал солилцсон байна.
- Хурлыг үр дүнтэй даргалсан байна.